

Израильчууд хорон мууд автаж гэм нүгэлд унажээ.

Үүнийг харсан Бурхан Филист хүмүүсээр дамжуулан Израильчуудыг зовоон шийтгэв.

Гэтэл нэгэн өдөр, Маноа гэдэг нэгэн хүүхэдгүй хүний гэрт Эзэний тэнгэр элч иржээ.

“Чи удахгүй хүүтэй болох болно. Тэр хүүгийн үсийг огт тайрч болохгүй. Тэр хүү том болоод Израилийг аюулаас аврах болно.”

Удалгүй Маноагийн эхнэр жирэмсэлж, хүү төрүүлэв. Тэд хүүгээ Самсон гэж нэрлэв.

Бурхан Самсонтой хамт байж түүнийг маш ихээр ерөөв.

Самсоны үс маш урт ургасан ч эцэг эх нь тэнгэр элчийн хэлсний дагуу үсийг нь огт тайрсангүй.

Самсон өсөж том болоод эрийн цээнд хүрчээ. Тэр маш хүчтэй хүчит баатар болов.

Самсон маш хүчтэй учраас Филистчүүд түүнээс айж байв.

Тэрээр арслан, баавгайнаас ч айхгүйгээр амыг нь зад татдаг байжээ.

Самсоноос болж Филистчүүд өөрсдийг нь зовоох вий гэж бодсон Израильчууд түүнийг гинжээр хүлээд Филистчүүдэд барьж өгсөн боловч Бурхан Самсонд хүчийг өгсөн болохоор тэр хүлээсийг дор нь тас татчихжээ.

Гэтэл Самсон үнэхээр үзэсгэлэнтэй нэгэн Филист эмэгтэйд дурлажээ. Түүний нэрийг Делила гэдэг байв.

Гэвч Делила мөнгөнд шуналтай эмэгтэй байж.

Нэгэн өдөр Самсоныг унтаж байхад нь Филистийн ноёдууд Делилатай уулзахаар ирэв.

“Делила аа, чи Самсоны аймшигт хүч чадлын нууцыг мэдээд өг. Яавал бид Самсоныг хүлж аваад хорих боломжтойг мэдүүлж өгвөл чамайг үнэхээр баяны баян нэгэн болгож өгье.” гэжээ.

Тэр өдрөөс хойш Делила Самсоны хүч чадал хаана байдгийг мэдэхийн тулд түүнийг ятгаж эхлэв гэнэ.

Гэвч Самсон Филист эмэгтэйд хэлэхгүй байв.

Делила Самсоныг өдөр бүр үгээр дарамталж байсанд түүний сэтгэл санаа мохож бүгдийг нь хэлжээ.

“Делила минь, би бол Бурханы хүн. Миний хүч чадал миний үсэнд байдаг юм.

Үсээ тайрвал би хүчээ алдана.”




Үүнийг сонссон Делила Самсоныг унтсан хойгуур үсийг нь тайрчихжээ.
Ингээд Самсон хүчгүй болов.
Филистчүүд Самсоныг бариад гинжээр хүлж, шоронд хийв.
Самсон гинжийг таслах гэсэн боловч ямар ч хүчгүй болсон учраас чадахгүй байлаа.
Бурхан аль хэдийн түүнээс холдон одсон учир тэрээр ямар ч хүчгүй болсон байлаа.
Филистчүүд түүний хоёр нүдийг сохлон, шоронд тээрмийн чулууг эргүүлдэг ажил хийлгэх болжээ.
Харин удалгүй Самсоны үс нь ургаж эхлэв.
Самсоныг барьсаны төлөө Филистчүүд том найр хийхээр цугларсан байлаа.
Филистчүүд бүгд том ордонд цуглан Самсоныг шооглон тохуурхаж байв.
Самсон хажуудаа байсан хүүгээс нэгэн зүйлийг хүсэв.
“Намайг энэ барилгын тулгуур багана уруу хүргээд өгөөч!”
Тэгээд Самсон тэр барилгын тулгуур хоёр багануудын хооронд гараараа тулж зогсоод Бурханд хандан залбирав.
“Бурхан минь! Энэ удаа л надад хүчийг өгөөч.
Намайг тамласан хүмүүсээс өшөөгөө авахыг минь зөвшөөрөөч. Би энэ хүмүүстэй хамт үхсэн ч хамаагүй!”
Ингээд Самсон залбирч дуусаад хамаг хүчээрээ хоёр баганыг түлхэв.
Хоромхон зуур тэр барилга нурж, дотор нь байсан бүх хүмүүс үхэв.
Самсоны үхэхдээ хөнөөсөн хүмүүс нь түүний амьд байхдаа хөнөөсөн хүмүүсээс ч хэд дахин их байв.
Ийнхүү Самсон Филистчүүдтэй хамт үхжээ.

- Дараах библийн эшлэлийг дагаж бицээд цээжлээрэй. (Шүүгцид 16:206)

ЭЗЭН түүнийг орхисныг...







Үйл ажиллагаа 2.

Цэгэн зураасын дагуу Самсоны үсийг хайчлаарай.

